ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шилүүстэй сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/121/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай сум<br>2022 он | Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 9999-3365<br>Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn<br><br>Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч: Г.Заяа<br>Утас: 9203-8288<br>Цахим хаяг: zayag@audit.gov.mn<br><br>Аудитор Г.Чулуунбаатар<br>Утас: 9908-4581<br>Цахим хаяг: chuluunbaatarg@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ........................................................**Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................................4
3. Аудитын тайлан........................................................................................................10
   3.1 Ерөнхий зүйл.......................................................................................................10
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................................11
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..............................................................11
   3.4 Материаллаг байдал ...........................................................................................11
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга...........................................................................11
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .........................................................11
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг...................................................13
   3.8 Аудитын гол асуудал ............................................................................................13
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ......................13
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .............................................................................13
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал..................................................................13
4. Аудитын илрүүлэлт ...................................................................................................13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ...............................................................14

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2022.02.24 № 1302/208.

танай ____________ -ны № ____________ -т

ШИЛҮҮСТЭЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Б.ЦЭРЭННАДМИД-д

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймгийн Шилүүстэй сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан аймгийн Шилүүстэй сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

01302/147

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мян.төг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **63,515.95** | **133,922.87** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 10,524.29 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 10,524.29 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 10,524.29 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 10,524.29 |
| **33** | **АВЛАГА** | 2,766.53 | 21,692.86 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 150.02 | 250.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 00.00 | 20,747.50 |
| **335** | **Бусад авлага** | 2,616.51 | 695.36 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 60,749.41 | 101,705.73 |
| **351** | **Түүхий эд материал** | 13,402.15 | 45,240.44 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 00.00 | 16,689.32 |
| 35130 | Эм боох материал | 13,402.15 | 28,551.12 |
| **354** | **Хангамжийн материал** | 47,047.26 | 56,165.29 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 109.70 | 167.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,015.24 | 3,942.84 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 500.00 | 193.58 |
| 35450 | Барилгын засварын материал | 3,859.80 | 3,859.80 |
| 35460 | Хүнсний материал | 4,055.96 | 7,239.78 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 35,506.56 | 40,762.28 |
| 35600 | Мал амьтад | 300.00 | 300.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **353,925.81** | **327,911.92** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 353,925.81 | 327,911.92 |
| **392** | **Биет хөрөнгө** | 342,511.81 | 316,497.92 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 232,917.38 | 232,917.38 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -17,732.12 | -26,598.18 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 34,691.43 | 34,691.43 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -8,272.29 | -13,691.43 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 197,224.86 | 217,393.32 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -125,561.04 | -151,913.60 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 68,995.09 | 70,034.99 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -39,857.30 | -46,441.79 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,277.52 | 3,277.52 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -3,277.52 | -3,277.52 |
| 39217 | Ном | 105.80 | 105.80 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 11,414.00 | 11,414.00 |
| 39301 | Програм хангамж | 620.00 | 620.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -620.00 | -620.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 11,414.00 | 11,414.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **417,441.76** | **461,834.79** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **100.00** | **410.45** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 100.00 | 410.45 |
| **413** | **Өглөг** | 100.00 | 410.45 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 100.00 | 200.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 210.45 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 210.45 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **417,341.76** | **461,424.34** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 417,341.76 | 461,424.34 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 801,715.05 | 801,715.05 |
| 51101 | Өмч: - төрийн | 801,715.05 | 801,715.05 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -402,478.56 | -358,395.98 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -402,478.56 | -402,478.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 44,082.58 |

| | | | |
|---|---|---|---|
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 18,105.27 | 18,105.27 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **417,441.76** | **461,834.79** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мян.төг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **494,017.37** | **792,105.84** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **490,625.67** | **792,105.84** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,159.79 | 200,758.25 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 94,022.20 |
| **122** | **Тусламжийн орлого** | 487,465.88 | 65,240.59 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 8,052.58 | 43,748.19 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 00.00 | 526,107.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 00.00 | 526,107.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,391.70** | **00.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,391.70 | 00.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,391.70 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **514,577.26** | **718,023.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **514,577.26** | **718,023.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 511,972.35 | 678,009.76 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 337,848.46 | 394,949.82 |
| 210101 | Үндсэн цалин | 337,848.46 | 206,442.64 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 148,118.41 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 5,376.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 35,012.77 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41,824.56 | 48,998.85 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,828.59 | 33,890.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,393.69 | 3,931.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,714.95 | 3,144.94 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 626.12 | 726.84 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,261.21 | 7,305.27 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 9,111.17 | 19,703.48 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,645.41 | 2,256.88 |
| 210302 | Түлш, халаалт | 6,384.47 | 17,389.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 81.30 | 57.20 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,095.89 | 26,670.62 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,018.46 | 1,356.05 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,588.96 | 18,832.47 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,042.80 | 1,102.80 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 181.50 | 07.86 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,264.17 | 5,371.45 |
| **2105** | **Нормативт зардал** | 39,569.94 | 68,877.02 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 32,053.92 | 60,633.47 |
| 210502 | Хоол, хүнс | 7,516.02 | 8,243.55 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,953.50 | 3,431.50 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 21.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,932.50 | 3,431.50 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 688.00 | 913.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 688.00 | 913.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,109.34 | 52,232.88 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 79.70 | 50,437.35 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 380.00 | 720.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 78.14 | 119.25 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 102.58 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 33.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 531.50 | 264.00 |
| 210807 | Газрын төлбөр | 40.00 | 40.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 00.00 | 516.70 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 48,771.49 | 62,232.58 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,341.75 | 15,010.33 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 44,429.74 | 47,222.25 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,604.91 | 40,013.50 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 540.00 | 40,010.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 540.00 | 40,010.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,064.91 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,064.91 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 03.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-20,559.88** | **74,082.58** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 30,000.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 30,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -30,000.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-20,559.88** | **44,082.58** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мян.төг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 801,715.05 | 18,105.27 | -370,652.22 | 449,168.10 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **801,715.05** | **18,105.27** | **-370,652.22** | 449,168.10 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -11,266,455.35 | -11,266.46 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **801,715.05** | **18,105.27** | **-402,478.56** | 417,341.76 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **801,715.05** | **18,105.27** | **-402,478.56** | 417,341.76 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **801,715.05** | **18,105.27** | **-402,478.56** | 417,341.76 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 44,082,579.89 | 44,082.58 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **801,715.05** | **18,105.27** | **-358,395.98** | 461,424.34 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мян.төг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **490,857.58** | **667,022.29** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **487,465.88** | **664,622.29** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 94,022.20 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 94,022.20 |
| **122** | **Тусламжийн орлого** | 487,465.88 | 44,493.09 |

| | | | |
|---|---|---|---|
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 8,052.58 | 23,000.69 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 00.00 | 526,107.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 00.00 | 526,107.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,391.70** | **2,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 2,400.00 |
| 131004 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | 00.00 | 2,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,391.70 | 00.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,391.70 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **479,617.58** | **655,798.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **479,617.58** | **655,798.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **477,012.68** | **615,784.60** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 337,760.50 | 394,949.80 |
| 210101 | Үндсэн цалин | 220,438.13 | 214,861.82 |
| 210102 | Нэмэгдэл | 87,387.60 | 140,325.21 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,722.54 | 4,750.00 |
| 210104 | Урамшуулал | 24,212.24 | 35,012.77 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41,393.84 | 48,808.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,400.88 | 33,700.18 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,390.69 | 3,931.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,714.95 | 3,144.94 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 626.12 | 726.84 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,261.21 | 7,305.27 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,715.81 | 19,203.48 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,645.41 | 2,256.88 |
| 210302 | Түлш, халаалт | 8,989.11 | 16,889.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 81.30 | 57.20 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,074.25 | 23,966.66 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,301.55 | 1,636.25 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,785.86 | 18,905.90 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,042.80 | 1,102.80 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 181.50 | 07.86 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,762.54 | 2,313.85 |
| **2105** | **Нормативт зардал** | 45,626.50 | 88,199.02 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 33,348.90 | 76,460.15 |
| 210502 | Хоол, хүнс | 9,548.20 | 11,278.87 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,729.40 | 460.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,527.50 | 3,842.90 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,284.50 | 951.40 |
| 210604 | Урсгал засвар | 6,243.00 | 2,891.50 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 688.00 | 913.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 688.00 | 913,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,559.34 | 14,551.77 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 79.70 | 12,940.23 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 380.00 | 380.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 78.14 | 119.25 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 102.58 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 33.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 531.50 | 336.70 |
| 210807 | Газрын төлбөр | 40.00 | 40.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 450.00 | 600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,666.93 | 21,349.56 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,666.93 | 21,349.56 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,604.91** | **40,013.50** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 540.00 | 40,010.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 540.00 | 40,010.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,064.91 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,064.91 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 03.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **11,240.00** | **11,224.19** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **11,240.00** | **699.90** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **11,240.00** | **699.90** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 11,240.00 | 699.90 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 11,240.00 | 699.90 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-11,240.00** | **-699.90** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 10,524.29 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 10,524.29 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мян.төг/

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны** | | **Тайлант оны** | |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 487,531.20 | 485,400.98 | 605,988.10 | 562,472.30 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 487,531.20 | 485,400.98 | 605,988.10 | 562,472.30 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 486,991.20 | 484,860.98 | 605,118.10 | 561,662.30 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 335,131.20 | 338,018.44 | 421,205.80 | 394,949.80 |
| 210101 | Үндсэн цалин | 213,950.90 | 229,075.29 | 253,805.90 | 214,861.82 |
| 210102 | Нэмэгдэл | 80,750.60 | 81,406.30 | 121,826.80 | 140,325.21 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,237.00 | 5,424.63 | 7,515.40 | 4,750.00 |
| 210104 | Урамшуулал | 34,192.70 | 22,112.24 | 38,057.70 | 35,012.77 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 44,856.70 | 41,135.90 | 56,862.80 | 48,808.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,495.50 | 27,782.59 | 40,014.60 | 33,700.18 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,590.30 | 3,325.98 | 4,212.10 | 3,931.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,872.20 | 2,660.75 | 3,369.60 | 3,144.94 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 718.10 | 669.73 | 842.40 | 726.84 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,180.60 | 6,696.86 | 8,424.10 | 7,305.27 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,897.40 | 11,741.21 | 18,597.40 | 19,203.48 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,760.60 | 2,165.71 | 2,760.60 | 2,256.88 |
| 210302 | Түлш, халаалт | 9,036.80 | 9,468.80 | 15,736.80 | 16,889.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 100.00 | 106.70 | 100.00 | 57.20 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,606.60 | 17,336.75 | 26,032.40 | 24,117.96 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,250.00 | 1,243.55 | 2,870.00 | 1,636.25 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,156.60 | 12,156.60 | 18,862.40 | 18,905.90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,100.00 | 1,087.80 | 1,100.00 | 1,102.80 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 900.00 | 657.29 | 1,200.00 | 159.16 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,200.00 | 2,191.51 | 2,000.00 | 2,313.85 |
| **2105** | **Нормативт зардал** | 43,542.30 | 43,702.30 | 39,617.30 | 46,318.92 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 31,485.00 | 31,279.90 | 23,560.00 | 34,580.05 |
| 210502 | Хоол, хүнс | 9,378.10 | 9,743.20 | 13,378.10 | 11,278.87 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,679.20 | 2,679.20 | 2,679.20 | 460.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 24,745.00 | 24,591.73 | 5,115.00 | 4,391.50 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,850.00 | 14,849.20 | 1,500.00 | 1,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 00.00 | 720.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,895.00 | 9,742.53 | 2,895.00 | 2,891.50 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 700.00 | 688.00 | 1,400.00 | 913.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 700.00 | 688.00 | 1,400.00 | 913.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,512.00 | 1,646.64 | 21,196.20 | 14,551.77 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 00.00 | 17,884.20 | 12,940.23 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 380.00 | 380.00 | 380.00 | 380.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 250.00 | 245.14 | 250.00 | 119.25 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 310.00 | 00.00 | 310.00 | 102.58 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33.00 | 00.00 | 33.00 | 33.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 800.00 | 531.50 | 1,600.00 | 336.70 |
| 210807 | Газрын төлбөр | 40.00 | 40.00 | 40.00 | 40.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 99.00 | 00.00 | 99.00 | 00.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 600.00 | 450.00 | 600.00 | 600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6000.00 | 6000.00 | 15091.20 | 8407.46 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,000.00 | 6,000.00 | 15,091.20 | 8,407.46 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 540.00 | 540.00 | 870.00 | 810.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 540.00 | 540.00 | 870.00 | 810.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 540.00 | 540.00 | 870.00 | 810.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 487,531.20 | 487,465.88 | 118,221.70 | 570,596.59 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 479,413.30 | 479,413.30 | 95,022.10 | 547,595.90 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 479,413.30 | 479,413.30 | 73,529.70 | 526,107.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 00.00 | 00.00 | 21,492.40 | 21,488.90 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 8,117.90 | 8,052.58 | 00.00 | 00.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 8,117.90 | 8,052.58 | 00.00 | 00.00 |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 00.00 | 00.00 | 23,199.60 | 23,000.69 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 00.00 | 23,199.60 | 23,000.69 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 10,524.29 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 27.00 | 28.00 | 25.00 | 28.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 20.00 | 21.00 | 19.00 | 21.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 06.00 | 05.00 | 06.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **27.00** | **28.00** | **25.00** | **28.00** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 21.00 | 21.00 | 19.00 | 21.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 06.00 | 07.00 | 06.00 | 07.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мян.төг/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **94,022.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **94,022.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 54,822.20 |
| **2105** | **Нормативт зардал** | 41,880.10 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 41,880.10 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,942.10 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,942.10 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 39,200.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 39,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 39,200.00 |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шилүүстэй сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн, аудитор Г.Чулуунбаатар нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Шилүүстэй сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шилүүстэй сумын Эрүүл мэндийн төв нь "Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг иргэдэд ээлтэй аюулгүй орчинд ёс зүйтэй, өндөр мэдлэг, ур чадвартай багаар жигд хүртээмжтэй үзүүлж, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлнэ" зорилгын дор үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлжээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж тус байгууллагад байхгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шилүүстэй сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардал 656,494.5 мянган төгрөгийн 1.5 хувь буюу 9,847.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 7,385.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 2,766.53 | 21,692.86 | 18,926.33 |
| Бараа материал | 60,749.41 | 101,705.73 | 40,956.32 |
| Үндсэн хөрөнгө | 353,925.81 | 327,911.92 | -26,013.89 |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | 417,441.76 | 461,834.79 | 44,393.03 |
| Өр төлбөр | 100.0 | 410.45 | 310.45 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 417,341.76 | 461,424.34 | 44,082.58 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 417,441.76 | 461,834.79 | 44,393.03 |

Авлагын дансны үлдэгдэл 21,692.86 мянган төгрөг болж өссөн нь 2021 онд ковидоор өвчилсөн иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын хэмнэлт буюу тухайн төсвийн жилд ашиглагдаагүй үлдэгдлийг төсвийн дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулахаар авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 101,705.73 мянган төгрөг болж өссөн нь Ковидтой холбоотойгоор тусгай зориулалтын, эм боох болон хүнсний материал худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 327,911.92 мянган төгрөг болж буурсан нь элэгдлээрээ өртгөө нөхөж байгаатай холбоотой байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 410.45 мянган төгрөг болж өссөн нь эмний үнэ болон 1 ажилтны цалин дутуу бодож олгосонтой холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дээд шатны төсөв захирагч тус байгууллагын 2021 оны төсвийн зарлагыг 605,988.1 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 582,788.5 мянган төгрөгөөр, тусламж санхүүжилтээр 23,199.6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 547,595.9 мянган төгрөгийн, хандиваар 23,000.69 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 94,022.2 мянган төгрөг, нийт 664,618.79 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 656,494.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 94,022.2 мянган төгрөгийн орлого хүлээн авч 100 хувь зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын үйл ажиллагаанд онцолж үзэх асуудал байхгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын үйл ажиллагааны зардал болох тээвэр шатахуун, эм, хүнсний материалыг нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байдлыг санхүүгийн аудитаар шалгахад материаллаг алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс 142 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроон оруулсан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд НББ-ийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн тайлагнаж Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг 95.3 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх материаллаг эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар нийт 92,299.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 75,635.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 16,527.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 136.4 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.1 **Залруулсан алдаа**

Харилцагч байгууллагын төлбөрийн баримтгүй /и-баримт/ 7,553.4 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийсэн.

Санхүүгийн үр дүнгийн тайланд борлуулалтын өртөгөөр 13,753.6 мянган төгрөг тайлагнасан, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг 20,528.3 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг 33,800.0 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.

4.2 **Төлбөрийн акт**

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар 2021 онд ковидоор өвчилсөн иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын хэмнэлт буюу тухайн төсвийн жилд ашиглагдаагүй үлдэгдлийг төсвийн дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулахаар авлага үүсгэсэн 16,527.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

4.3 **Албан шаардлага**

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй болно.

4.4 **Зөвлөмж**

Харилцагч байгууллагын төлбөрийн баримтгүй /и-баримт/ 136.4 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийсэн, 2022 онд харилцагч байгууллагын төлбөрийн баримтаар /и-баримт/ баталгаажсан ажил гүйлгээг хийх.

Зөвлөмжийн хариуг 2022.10.01-ний өдрийн дотор албан тоотоор ирүүлэх

---

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Шилүүстэй сумын Эрүүл мэндийн төв | 6 | 92,299.6 | 4 | 75,635.3 | 1 | 16,527.9 | - | - | 1 | 136.4 |

**БОЛОВСРУУЛСАН:**

АУДИТОР Г.ЧУЛУУНБААТАР

**ХЯНАСАН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЗАЯА

2022.02.25